

## “БУЛЛ КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Булл капитал ББСБ” ХХК-ийн 2023 оны Үйл ажиллагааны нэгдсэн тайланг хүргэж байна. Компанийн хувьд тухайн жилд Бизнес төлөвлөгөөний дагуу тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн ханган ажилласныг мэдээллэхэд таатай байна.

Бид 2023 онд уламжлалт зээл буюу Бизнесийн зээл, бизнесийн зээлийн шугам, автомашины зээл, хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн болон Итгэлцэлийн үйлчилгээг зах зээлд салбар нэгжүүдээрээ дамжуулан харилцагчдад санал болгон ажиллалаа.

№	Үндсэн ажиллагааны хүрээнд:
1	Оюуны өмчийн газарт компанийн “BULL CAPITAL” үг бүхий лого-г албан ёсоор бүртүүлэн Барааны тэмдэгийн гэрчилгээг хүлээн авсан.
2	Компанийн дүрмийн сангийн хэмжээг нийт 4.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 12.2 тэрбум төгрөгт, улмаар өөрийн хөрөнгийн хэмжээг 18.4 тэрбум төгрөгт тус тус хүргэсэн.
3	Компанийн санхүүгийн үр дүн, гүйцэтгэлийг дүгнэснээр нийт ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг 30 хүртэл хувиар нэмэгдүүлж, үр дүнгийн урамшуулал олгосон.
4	Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Өлзийт аккаунт аудит” ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэж баталгаажуулан, Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны вэб сайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн.
5	Биржийн бус захаас 2022 оны 7 сард татан төвлөрүүлсэн 2.2 тэрбум төгрөгийн дүнтэй “Булл бонд-1”-ийг хүүний хамт хугацаанд нь төлж, хөрөнгө оруулагч нарын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн.
6	ҮЦАЭХ-ны зөвшөөрлийн дагуу Биржийн бус зах дээр 2023 оны 02-р сарын 13-ны өдөр 2.2 тэрбум төгрөг, 2023 оны 08-р сарын 18-ны өдөр 3.4 тэрбум төгрөг, нийт 5.6 тэрбум төгрөгийн дүн бүхий хаалттай бондыг “Стандарт инвестмент ҮЦК” ХХК, “Кэй И партнерс” ХНХ-уудтай хамтран амжилттай гаргасан.
7	Компанийн <a href="http://www.bullcapital.mn">www.bullcapital.mn</a> вэб сайтыг шинэчилсэн бөгөөд тус вэб сайтаар дамжуулан байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, мэдээ мэдээлэл, санхүү болон үйл ажиллагааны тайланг харилцагч нарт илүү хүртээмжтэй болгосон.
8	Санхүүгийн байгууллагууд болон “Булл бонд-2”, “Булл бонд-3”-ын хөрөнгө оруулагчид мөн Итгэлцэл байршуулсан харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь бүрэн биелүүлэн ажиллалаа.
9	“Автоцогцолбор”, “Да хүрээ” салбаруудыг шинээр байгуулснаар нийт 7 салбартай болж, борлуулалтын суваг, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.






10	Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд 19 ажилтан шинээр нэмж, 4 ажилтан албан тушаал дэвшиж, 6 ажилтан ажлаас чөлөөлөгдсөнөөр үндсэн ажилтны тоо 27 болсон.
11	Компанид мөрдөгдөж буй нийт бодлого, дүрэм, журамд үнэлгээ хийж, тус үнэлгээний дагуу 16 бодлого, дүрэм, журамд шинэчлэлт хийж, 2 дүрэм, журмыг шинээр боловсруулсан.
12	<p>Төлөөлөн удирдах зөвлөл нийт 35 удаа хуралдаж, 35 асуудлыг хэлэлцсэнээс хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн 60-100% ирцтэйгээр хэлэлцэн шийдвэрлэсэн ба нийт 35 тогтоол баталсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Хаалттай хүрээнд Үнэт цаас гаргахтай холбоотой 2 тогтоол,</li><li>✓ Компанийн дүрмийн сан нэмэгдүүлэхтэй холбоотой 2 тогтоол,</li><li>✓ Төсвийн төлөвлөгөө хэлэлцэн батлахтай холбоотой 1 тогтоол,</li><li>✓ ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод, түүний бүтэц зохион байгуулалттай холбоотой 5 тогтоол,</li><li>✓ Компанийн үндсэн үйл ажиллагааг эсрдэлгүй, тогтвортой, тасралтгүй явуулах хүрээнд 15 тогтоол,</li><li>✓ Сонирхлын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний хэлцэлтэй холбоотой 10 тогтоол.</li></ul>
13	Харилцагчийн үйлчилгээний стандартыг хэрэгжилтийг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд үйлчилгээний ажилтнуудыг дүрэмт хувцсаар жигдрүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулахад онцгой анхаарсан.
<b>Эрсдэлийн удирдлага:</b>	
14	Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, Төрийн зохицуулагч байгууллагуудын шийдвэр, чиглэлийг анхааралтай ажиглаж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь шуурхай авч ажилласан.
15	Бүтээгдэхүүн, Санхүү, Комплаенс, Үйл ажиллагааны эрсдэл тэдгээртэй холбоотой процессыг үнэлж, нэгжүүдийн хооронд уялдаа холбоог сайжруулсан.
16	<p><b>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь</b> эрсдэлийн төрөл, хэмжээ, хязгаарыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн нийт 5 удаа, 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>➤ Эрсдэлийн удирдлагын бодлого, Комплаенсийн бодлого, Санхүүгийн удирдлагын бодлого, Зээлийн бодлогыг баталсан.</li><li>➤ Компанийн боловсруулсан Комплаенсийн эрсдэлийн үнэлгээнд дүгнэлт гаргаж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.</li><li>➤ Их хэмжээний хэлцэл хийхтэй холбогдуулан эрсдэлийн дүгнэлт гаргаж, шийдвэрлэсэн.</li><li>➤ Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд улирал бүр санхүү, хууль, эрсдэл, комплаенс, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан нэгжүүдээс холбогдох</li></ul>



	тайлан, мэдээнүүдийг авч хэлэлцэн, Гүйцэтгэх удирдлага, эрсдэл хариуцсан нэгжид зохих зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан.
17	<p><b>ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь</b> тайлангийн хугацаанд нийт 3 удаа, 80-100 хувийн ирцтэйгээр хуралдсан. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь эрсдэлийн удирдлага, санхүү, нягтлан бодох бүртгэл болон тайлан, хөндлөнгийн аудитортой хамтран ажиллах, дотоод хяналт, хууль, журам мөрдөх гэсэн 5 чиглэлийн дагуу ажиллаж байна. Дотоод аудитын хэлтэс нь төлөвлөгөөний дагуу нэгжүүдэд төлөвлөгөөт аудитын хяналт хийсэн.</p> <p>Аудитын хороо нь Дотоод аудитын хэлтсийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шууд удирдлагаар хангаж ажилласан. Мөн хороо нь “Дотоод аудитын үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулж, компанийн ТУЗ-өөр батлуулж, үйл ажиллагаанд мөрдөж байна. 2023 онд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийх хэлцлийн талаар дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн.</p>
18	Санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор давхар болон дараалсан хяналтын систем нэвтрүүлж, мөнгөн урсгал төлөвлөлтийг тогтмол хийн хөрвөх чадварыг ханган ажилласан.
19	Санхүүгийн Зохицуулах хорооноос мөрдүүлдэг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа”-ны тоон болон чанарын шаардлагыг хангахад чиглэсэн сургалт, судалгааг хийж ажилласан.
<b>Байгаль орчин, нийгэм эдийн засгийн эрсдэлийн удирдлага:</b>	
20	“Эрсдэлийн удирдлагын бодлого”-д эрсдэлийн төрлийг Зах зээлийн эрсдэл, Зээлийн эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Хууль эрх зүйн эрсдэл, Комплаенсын эрсдэл, Хөрвөх чадварын эрсдэл, Байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэл гэж ангилан авч үзэхээр тодорхойлсны дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
21	“Зээлийн бодлого”-д Байгаль орчин, нийгэм эдийн засагт ээлтэй байх стандартыг баримталж ажиллах, Монгол улсын хууль тогтоомжид хориглосон үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх зохицуулалтыг тусгасны дагуу бид зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан байгаль орчин, хүн амд хор хөнөөл учруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого барьж ажилласан.
22	ТоС холбооны гишүүн байгууллагын хувьд ТоС холбооноос хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэлэлцүүлэгт оролцож, байгаль орчинд ээлтэй байх зарчмын хүрээнд ажиллалаа.
<b>Сургалт, хөгжүүлэлт чиглэлээр:</b>	
23	Салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн туршлагатай, гадны сургагч багш нарыг 2 удаа урьж, нийт ажилтнуудад “Ёс зүй, багийн ажиллагаа”, “Тэр бүлийн сэтгэл зүй” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.
24	Олон улсын санхүүгийн корпораци болон СЗХ, ТоС холбоо хамтран зохион байгуулсан ТоС-



	ийн суурь ойлголт өгөх 7 модуль онлайн сургалтад компанийн нийт ажилтнуудыг хамруулсан.
25	Ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор шаардлагатай чиглэл бүрээр ажилтнуудыг компанийн дотоод сургалтад 16 удаа, гадаад сургалтад 15 удаа тус тус хамруулсан. Мөн СЗХорооноос зохион байгуулсан “Итгэлцлийн үйл ажиллагааны журам” хэлэлцүүлэг, “Комплайнс-Удирдах ажилтны манлайлал” сургалт, “Комплаенсын эрсдэлийг удирдахуй” хэлэлцүүлэг, “ББСБ-ын нягтлан бодогч нарт зориулсан сургалт”, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн сургалт, Санхүүгийн мэргэшүүлэх академийн сургалт, Хүний нөөцийн клубээс зохион байгуулсан “Банк, санхүүгийн ажилтны орчин үеийн хүний нөөцийн нөхцөл байдал”, СЗХ болон МББСБХ, Санхүүгийн боловсролын HUB сургалтын байгууллагаас зохион байгуулсан "Комплаенсын ажилтныг мэргэшүүлэх" зэрэг сургалтуудад хариуцсан ажилтнуудыг тус тус хамруулсан.
26	Нийт ажилтнууд дунд Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон Дотоод хяналтын хөтөлбөрийн талаар сургалт зохион байгуулсан.
27	СЗХ, ТоС холбоо болон ОУСК-аас хамтран “ББСБ-уудын үйл ажиллагаанд Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх” сургалт болон ТоС холбооноос зохион байгуулсан хэлэлцүүлэг, сургалтуудад хариуцсан ажилтнуудаа тогтмол хамруулсан.
<b>Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр:</b>	
28	“Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр” болон “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын дагуу хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудтай хамтран ажиллахдаа харилцан ашигтай байх, тэдгээрт тогтсон цаг хугацаанд буюу санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар хүргэж байна.
29	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, стратеги түүний хэрэгжилтийн мэдээлэл, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд гарсан томоохон өөрчлөлт, Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүдийн талаарх мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллүүдийг Хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудад <a href="http://www.bullcapital.mn">www.bullcapital.mn</a> цахим хуудас, биечилсэн уулзалт, <a href="mailto:info@bullcapital.mn">info@bullcapital.mn</a> цахим шуудан, 77303377 лавлах утасны дугаар, холбоо харилцааны бусад хэрэгслүүдийг ашиглан тогтмол нээлттэй мэдээллэж, санал хүсэлт, гомдлыг мөн нээлттэй хүлээн авч шийдвэрлэх, сайжруулах тасралтгүй систем ажиллаж байна.
30	Дотоодын зах зээлд тэргүүлэгч арилжааны банк, санхүүгийн байгууллагууд, даатгалын компаниудтай хамтын ажиллагаа улам өргөжин тэлсэн.

Нийгмийн хариуцлагын хүрээнд:	
31	 <p>Компанийн нийт ажилтнууд болон тэдний гэр бүлийнхний дунд нөхөрсөг спорт өдөрлөг зохион байгуулсан.</p>
32	<p>“Гранд мед” болон “Бриллиант” эмнэлгүүдтэй хамтран компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн цогц шинжилгээ, оношлогоо, үзлэгт хамруулсан.</p>
33	<p>Эх үрсийн баярыг тохиолдуулан нийт ажилтнуудын хүүхдүүдийн дунд уралдаан зарлаж, хүлээн авалт хийсэн ба аав, ээжийнх нь ажлын байртай танилцуулж, компанийн зүгээс хүүхдийн баярын бэлэг гардуулсан.</p>
34	 <p>Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг байгаль орчинд ээлтэй ажлын хүрээнд хамт олноороо 2023 оны 6-р сарын 18-ны өдөр Сонгинохайрхан уулын ойр орчмын хогийг цэвэрлэсэн.</p>
35	<p>Байгууллагын хамт олны эерэг уур амьсгал, соёлыг хадгалах, бүрдүүлэх зорилготой зуны арга хэмжээг зохион байгуулсан.</p> 

### Санхүүгийн үзүүлэлт:

Компанийн 2021, 2022, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлтүүд (сая төгрөг)	2021	2022	2023	Өөрчлөлт
	Аудитлагдсан	Аудитлагдсан	СЗХ-нд илгээсэн	2023/2022
<b>Санхүү байдлын тайлан</b>				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12.56	2,209.36	3,283.87	49%
Нийт зээл	1,931.89	22,223.77	47,597.28	114%
Зээлийн эрсдэлийн сан		-124.27	-722.17	481%
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	39.84	626.34	1,420.73	127%
Бусад авлага	5.64	217.12	94.48	-56%
Бусад хөрөнгө	16.82	40.65	297.22	631%
Үндсэн хөрөнгө	20.85	173.63	217.02	25%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,027.61</b>	<b>25,366.60</b>	<b>52,188.44</b>	<b>106%</b>
Итгэлцэл, бусад өр төлбөр	604.80	16,314.42	33,708.87	107%
Дүрмийн сан	1,400.00	7,400.00	12,199.83	65%
Хуримтлагдсан ашиг	22.81	1,652.17	6,279.74	280%
<b>Нийт өр төлбөр, эзний өмчийн дүн</b>	<b>2,027.61</b>	<b>25,366.60</b>	<b>52,188.44</b>	<b>106%</b>

<b>Орлого, үр дүнгийн тайлан</b>				
Хүүгийн орлого	69.97	4,109.23	13,395.79	226%
Хүүгийн зардал	8.56	963.16	2,691.07	179%
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>61.41</b>	<b>3,146.07</b>	<b>10,704.72</b>	<b>240%</b>
Хүүгийн бус орлого	9.71	229.49	992.93	333%
Хүүгийн бус зардал	44.54	1,390.35	3,808.63	174%
Эрсдэлийн сангийн зардал	0.00	124.27	597.89	381%
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>	<b>26.57</b>	<b>1,860.94</b>	<b>7,291.13</b>	<b>292%</b>
Ү/А-ны бус орлого				
Ү/А-ны бус зардал	3.50	47.49	96.46	103%
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>23.08</b>	<b>1,813.46</b>	<b>7,194.67</b>	<b>297%</b>
Орлогын татварын зардал	0.27	184.09	915.10	397%
<b>Цэвэр ашиг</b>	<b>22.81</b>	<b>1,629.37</b>	<b>6,279.57</b>	<b>285%</b>

2023 оны жилийн эцсийн санхүүгийн үзүүлэлтүүдийг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт хөрөнгө 26.8 тэрбум төгрөг буюу 106%-иар, нийт зээлийн багц 25.3 тэрбум төгрөг буюу 114%-иар тус тус өссөн. Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 1.4% байна.

“Булл бонд-2” болон “Булл бонд-3”, мөн Банк, санхүүгийн байгууллага болон Итгэл хүлээлгэгч нараас шаардлагатай эх үүсвэрүүдийг амжилттай татсанаар бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн 33.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны эцсээс 107.0%-иар өссөн.

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнд 2023 оны жилийн эцсийн байдлаар татварын дараах цэвэр ашиг 6.27 тэрбум төгрөгт хүрсэн ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьдаг зохистой харьцааны бүх шалгууруудыг ханган ажиллалаа.

**“БУЛЛ КАПИТАЛ ББСБ” ХХК**

**2024.01.19**